



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 1/18

Мөрөн сум

Аяны үнэлгээг баталгаажуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, 36 дугаар зүйлийн 36.6, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 04 дүгээр тогтооолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс болон Орон нутгийн өмчийн газар, Санхүүгийн хяналт, аудитын албанаас хамтран зохион байгуулсан “Манлайлагч санхүүгийн алба” аяны болзлыг ханган сумдын санхүүгийн албыг хошуучлан манлайлж ажилласан Баянзүрх сумын санхүүгийн албыг “2023 оны Манлайлагч Санхүүгийн алба”-аар шалгаруулж, үйл ажиллагаанд нь шаардлагатай тоног төхөөрөмжөөр урамшуулсугай.


2. Аяны хүрээнд нэгдүгээр байр эзэлсэн Баянзүрх сумын санхүүгийн албаны ажилтнуудыг нэг сарын үндсэн цалингийн 30 хувиар, хоёрдугаар байр эзэлсэн Ренчинлхүмбэ сумын санхүүгийн албаны ажилтнуудыг нэг сарын үндсэн цалингийн 25 хувиар, гуравдугаар байр эзэлсэн Тариалан, Төмөрбулаг сумдын санхүүгийн албаны ажилтнуудыг нэг сарын үндсэн цалингийн 20 хувиар, дөрөвдүгээр байр эзэлсэн Мөрөн сумын санхүүгийн албаны ажилтнуудыг нэг сарын үндсэн цалингийн 15 хувиар, тавдугаар байр эзэлсэн Чандмань-Өндөр сумын санхүүгийн албаны ажилтнуудыг нэг сарын үндсэн цалингийн 10 хувиар тус тус нэг удаа шагнаж урамшуулахыг Төсвийн шууд захирагч нарт зөвшөөрсүгэй.

3. Аяны хүрээнд сүүлийн байруудад орсон Бүрэнтогох, Эрдэнэбулган, Рашаант, Түнэл, Ханх сумдын Засаг дарга нарт төсөв санхүүгийн талаар гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахад анхаарч, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах талаар төлөвлөгөө гарган, улирал бүр хэрэгжилтийг тооцон ирүүлж, хариуцлагатай ажиллахыг үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, Төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар)-т үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Захирамж2024

671010683